



НИЙСЛЭЛИЙН  
АГААРЫН БОХИРДЛЫГ БУУРУУЛАХ ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2017 оны 10 сарын 04 өдөр

Дугаар А/20

Улаанбаатар хот

Ёс зүйн хороог шинэчлэн байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Засгийн газрын 2010 оны 288 дугаар тогтоол "Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрэм", Төрийн албаны зөвлөлийн 2010 оны 129 дүгээр тогтоолоор батлагдсан "Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг зохион байгуулах, ёс зүйн зөрчлийг хянан шийдвэрлэх журам"-ыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Байгууллагын Ёс зүйн хороог Захиргааны хэлтсийн дарга О.Мягмарсүрэн, Дахин төлөвлөлт, дулаан хангамж хариуцсан ахлах мэргэжилтэн Г.Бат-Оюун, Хөдөлгөөнт эх үүсвэрийн хэмжилт хариуцсан ахлах мэргэжилтэн О.Алтангэрэл нарын бүрэлдэхүүнтэйгээр шинэчлэн байгуулж, даргаар нь О.Мягмарсүрэнг томилсугай.

2. Албан хаагчдын үйл ажиллагаанд Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг зохион байгуулах, Ёс зүйн зөрчлийг хянан шийдвэрлэх журам, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийг мөрдлөг болгон ажиллахыг ёс зүйн хорооны дарга /О.Мягмарсүрэн/-нд үүрэг болгосугай.

3. Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн тухай гомдол, мэдээллийг хүлээн авч, түүний үндэслэлийг шалган тогтоож, дүгнэлт гаргах эрх бүхий ёс зүйн байнгын хороог байгуулан ажиллаж буйтай холбоотойгоор нийт албан хаагчдад энэ талаар гарсан хууль тогтоомжийг судлан, мөрдлөгө болгон ажиллахыг даалгасугай.

ДАРГА



М.ДЭЛГЭРЭХ